



**НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2004 оны 5 сарын 28 өдөр

Дугаар 254

Улаанбаатар хот

**Ерөнхий боловсролын сургуулийн
хэв шинжийг өөрчлөх тухай**

Монгол Улсын “Боловсролын тухай” хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 дугаар заалт, “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай” хуулийн 16 дугаар зүйлийн 2-ын 4 дэх заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

Нэг. 2004 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн Ерөнхий боловсролын сургууль байгуулах тусгай зөвшөөрөл олгох комиссын хурлын шийдвэрээр “Сакура” хувийн бага сургууль /М.Дэлгэрмаа, Ж.Амараа/, “Орлёнок” бага сургууль /М.Халиун/, “СанЛизэ” бага сургууль /М.Алтанчимэг/, “Сод” бага сургуулийг /Я.Саруул/, “Энх” бага сургууль /Ц.Батболд/, “Эрин” бага сургууль /А.Бассувд /, “Арга билэг “ бага сургуулийг / Б.Болормаа /, “Билгүүн далай” бага сургууль / Д.Энхбаяр/-ийг бүрэн дунд сургуулийн хэв шинжээр өөрчлөн зохион байгуулахыг тус тус зөвшөөрсүгэй.

Хоёр. Хувийн бүрэн дунд сургуулийг хуулинд заасны дагуу Улсын бүртгэлд бүртгэж, тусгай зөвшөөрөл олгон, хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Нийгмийн хөгжлийн бодлогын хэлтэс /Ш.Наран/ , Боловсролын газар /М.Лхан- Аажав / , Дүүргүүдийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ

М.ЭНХБОЛД